БАТЛАВ:

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР

. . . . . /Ц.ТУЛГА/

СҮХБААТАР ДҮҮРЭГ 15,17 ДУГААР ХОРООНЫ ИНЖЕНЕРИЙН БЭЛТГЭЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

2023 оны 04-р сарын 27-ны өдөр Дугаар:МЗХ2023/13-001 Улаанбаатар хот

1.	Зураг төсөл боловсруулах үндэслэл	- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого - Монгол Улсын Их хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг; - Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл ; - /Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр; - Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 94 дүгээр тогтоолоор баталсан Төрөөс орон сууц, нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлого; - Засгийн газрын 2019 оны 202 дугаар тогтоолоор батлагдсан "150 мянган айл" орон сууц үндэсний хөтөлбөр; - Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 02/09 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"; - Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 02/10 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"; - Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны 63 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын төлөвлөлтийн хойд бүсийн Дамбадаржаа" нэгж хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө; - 2023 оны Мэргэжлийн зөвлөлийн 13 дугаар хурлын шийдвэр
2.	Зураг төсөл боловсруулах үе шат хугацаа	**1 үе шаттай.** - Үерийн хамгаалалтын далан сувгийн ажлын иж бүрэн зураг төсөл, төсөв - Зам талбайн борооны ус зайлуулах шугам сүлжээний ажлын иж бүрэн зураг төсөл, төсөв - Хөрсний ус доошлуулах шүүрүүлийн байгууламжийн ажлын иж бүрэн зураг төсөл, төсөв **Хугацаа** Гэрээнд заасан хугацаагаар
3.	Байршил, газар эдэлбэрийн одоогийн байдал	- Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 15,17 дугаар хорооны гэр хорооллын гудамж 100 га

4.	Ажлын зураг төсөл боловсруулахад ашиглах материал	**Монгол Улсын хуулиуд:** - Монгол улсын үндсэн хууль; - Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль; - Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль; - Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль; - Хот байгуулалтын тухай хууль; - Барилгын тухай хууль; - Байгаль орчныг хамгаалах тухай хууль; - Газрын тухай болон Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль; - Усны тухай хууль; - Гамшгаас хамгаалах тухай; - Хот суурин газрыг дахин хөгжүүлэх хууль; - Бусад холбогдох хууль тогтоомжууд **Норм, нормативууд:** - Монгол орны нутаг дэвсгэрт тархсан олон жилийн цэвдэг хөрсөнд инженер-геологийн судалгаа хийх заавар /БД 50-102-08/ - Усны барилга байгууламжийн инженер, хайгуул судалгааны ажлын жишиг норм /БД 81-105-11/ - Усны барилга байгууламжийн зураг төслийн ажлын жишиг норм /БД 81-106-11/ - Усны барилга байгууламжийн зураг төсөл зохиох үндсэн журам /БНбД 33-01-03/ - Усны барилга байгууламжийн ачаалал ба үйлчлэл /БНбД 33-05-09 - Усны барилга байгууламжийн бетон ба төмөр бетон бүтээц /БНбД 33-06-09 - Усны барилга байгууламжийн хайгуул судалгааны ажлын жишиг норм /БД 81-33-10/ - Усны барилга байгууламжийн буурь /БНбД 33-04-09/ - Усны барилга байгууламжийн төсвийн суурь норм /БНбД 81-33-10/ - Голын гидротехникийн барилга байгууламж /БНбД 33-03-05/ - Хот тосгон нутаг дэвсгэр, зам талбайгаас бороо, цасны усыг зайлуулах ажлын зураг төсөл, тооцооны норм /БД40-302-13 - Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилт /БНбД 30-01-04/ - Барилгад хэрэглэгдэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт /БНбД 23.01.09/ - Авто замын гүүр ба хоолой төсөллөх /БНбД 32-02-03/ - Авто зам төсөллөх ЗЗБНбД 22-004-2016 - Хот суурины гудамж, зам төлөвлөлт /БД 32-01-04/ **Холбогдох журмууд:** - Монгол улсын Засгийн газрын 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 108 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах магадлал хийх дүрэм" - Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2018 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 09 дүгээр тогтоолоор батлагдсан "Нийслэлийн инженерийн бэлтгэл арга хэмжээний барилга байгууламжийн төлөвлөлт, хамгаалалтын зурвас, ашиглалт засвар үйлчилгээний журам" **Бусад холбогдох норм, дүрэм, заавар**

5.	Хэрэглэгчийн ачаалал	- 2017 оны 63 дугаар тогтоолоор батлагдсан Улаанбаатар хотын төлөвлөлтийн хойд бүсийн "Дамбадаржаа" нэгж хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө"-ний дагуу ус хураах талбай болон ус зүйн тооцоо хийх
6.	Ажлын зураг төслийн бүрдэл, шаардлага	**Инженерийн бэлтгэл арга хэмжээний шугам сүлжээ:** Талбайд орчны судалгаа, инженер геологи, гидрогеологи, гидрологи ус зүйн тооцоо судалгаа хийж - Үерийн хамгаалалтын байгууламжийн ажлын иж бүрэн зураг төсөв - Гэр хорооллын гудамжны зам талбайн борооны ус зайлуулах шугам сүлжээний ажлын иж бүрэн зураг төсөв - Хөрсний ус доошлуулах шүүрүүлийн байгууламжийн ажлын иж бүрэн зураг төсөв Баримт бичгийн иж бүрдэл: - Тайлбар бичиг - Инженер геологийн дүгнэлт - Геологи, гидрологи, ус зүйн тооцоо судалгаа - Ажлын тоо хэмжээ - Материалын түүвэр - Үерийн хамгаалалтын байгууламжийн ажлын иж бүрэн зураг төсөл - Гэр хорооллын гудамжны зам талбайн борооны ус зайлуулах шугам сүлжээний ажлын иж бүрэн зураг төсөл - Хөрсний ус доошлуулах шүүрүүлийн байгууламжийн ажлын иж бүрэн зураг төсөл - Хөрөнгө оруулалтын тооцоо төсөв - Дэвсгэр зураг, зай хэмжээ, өндөржилт М1:500 - Магадлалын нэгдсэн дүгнэлт **Зураг төсөлд тавигдах шаардлага:** - Зураг төслийн баримт бичиг 4 хувь. Үүнээс: график зураглал CD-ний хамт 2 хувийг захиалагчид, үндсэн хувийг архивд өгнө. - Инженерийн шугам сүлжээний ажлын зургийг UTM-координатын системд хийж гүйцэтгэн батлагдсан ажлын зургийг CD-ээр Хот байгуулалт хөгжлийн газрын Инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтэст хүлээлгэн өгөх. - Ажлын зурагт бусад инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийг нэг дэвсгэр дээр нэгтгэн, хоорондын зай хэмжээг огтлолын зургаар тодорхой үзүүлж, норм стандартын дагуу төлөвлөж, шугам сүлжээний ашиглалтын байгууллагуудтай зөвшилцсөн байх шаардлагатай. - Ажлын зураг, тайлбар бичиг, инженер геологийн дүгнэлт, геодезийн ажлын тайлан бусад холбогдох бичиг баримтыг эх хувь 1ш, хуулбар хувь 3ш (хуулбар хувийг өнгөтөөр хувилж авчрах), тоон хэлбэрээр /DWG болон PDF/ хүлээлгэж өгнө.
7.	Инженерийн хангамжийн байгууламжийн үндсэн хийцэд тавигдах шаардлага.	**Инженерийн бэлтгэл арга хэмжээний шугам сүлжээ** - Инженер геологийн судалгаанд үндэслэн цэвдэгтэй болон хөрсний усны түвшинг тооцож хөрсний ус доошлуулах шүүрүүлийн байгууламж төлөвлөх - Болзошгүй үерийн аюулыг 1, 5, 10 %-ийн хангамшлын зарцуулалтыг тодорхойлж, тооцоот зарцуулгыг 1%-ийн хангамшлаар тооцож борооны ус зайлуулах шугам сүлжээ, үерийн хамгаалалтын барилга байгууламж шинээр төлөвлөх

		- Усны барилга байгууламжийн холболтын цэгийг ашиглагч "ГУББГ,ОНӨААТҮГ"-аас техникийн нөхцөл авч нэгдсэн шугам сүлжээнд холбох - Хаврын шар ус, зуны хур борооны үед сайр, гуу жалгаар урсан ирэх урсацын хагшаас тогтоон барих байгууламж, үерийн ус хүлээж авах байгууламж, энерги унтраах, тунгаагуурын байгууламж төлөвлөх, - Байгууламжид нийлэх гуу жалга түүний оруулга, дагалдах хийц, бэхэлгээний хийцийн тооцоо хийх, хатуу урсацын хэмжээ тодорхойлох . - Авто замын ус гаргуурыг ус хураах талбай, ус зүйн тооцоо нарийвчлан хийж хөндлөн огтлолын хийцийг төлөвлөх - Трассын дагууд огтлолцож байгаа бусад инженерийн шугам сүлжээг хамгаалах, бэхлэх арга хэмжээг төлөвлөж, эзэмшигч байгууллагуудтай зөвшилцөх, ашиглагч байгууллагаас техникийн нөхцөл гаргуулах, шаардлагатай тохиолдолд шугам сүлжээг шилжүүлэх зургийг боловсруулах. - Трассанд өртөж байгаа нэгж талбаруудыг зурагт тэмдэглэж газар чөлөөлөлтийн зардал тооцох, холбогдох байгууллагуудтай зөвшилцөх, статистик мэдээлэл гаргах, зураг схем гаргаж өгөх. - Байгууламжийн трасст орсон барилга байгууламж, нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн тохижилт, авто замын нөхөн сэргээлтийг төсөвт тусган тооцоо,судалгааг нарийвчлан гаргаж тайлбар бичигт тусгах - Авто замын байгууламжийн доор төлөвлөж буй хэсгийг сувган байгууламжид оруулах - Хэтийн төвөгшлийн зэргийг тооцож зөв оновчтой трасс сонголтыг хийх.
8.	Шугам сүлжээний трасс сонголтонд тавигдах шаардлага	- Авто зам, төмөр зам, инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг тогтоох, - Бусад инженерийн шугам сүлжээний төлөвлөсөн ажлын зурагтай уялдуулах. - Трассанд өртөж байгаа нэгж талбаруудыг зурагт тэмдэглэж газар чөлөөлөлтийн зардал тооцон төсөвт тусгах, холбогдох байгууллагуудтай зөвшилцөх
9.	Эдийн засгийн тооцоо, төсөв	- Эдийн засгийн тооцоог УББ 80-204-16 "Хөрөнгө оруулалтын үр ашгийг тооцох заавар"-аар, төсвийг БНбД 81-95-12 болон эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн програмаар тооцно. - Хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан төсвийг үе шаттайгаар тооцох - Одоо байгаа авто зам, замын хөндлөн гарах гаргалгааны хэсэгт мэргэжлийн байгууллагаас тавьсан шаардлагыг нарийвчлан тусгаж, нөхөн сэргээлтийн зардлыг төсөвт тусгана.
10.	Зураг төсөл боловсруулах байгууллага	- Зөвлөх үйлчилгээний **1.3.5** "Усны барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах"тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж эсвэл **ЗТ-2.2, ЗТ-3.2, ЗТ-4.2, ЗТ-5.2** "Усны барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах"тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж
11.	Зураг төслийн санхүүжилт	- Орон нутгийн сангийн хөрөнгөөр
12.	Төслийн захиалагч	- Сүхбаатар дүүргийн Засаг даргын тамгын газар

13.	Галын аюулгүй байдлын нөхцөл	- Барилга, байгууламжийн галын аюулгүйн байдал БНбД 21-01-02 - Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм БНбД 21-02-02
14.	Байгаль орчны үнэлгээ нөхцөл	Шаардлагатай тохиолдолд байгаль орчны ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийлгэх
15.	Онцгой нөхцөл (Төлөвлөлтийн шаардлагаар гарах нэмэлт шаардлагууд трассын дагуух газар чөлөөлөх, хөрсний шинж чанараас хамаарсан нэмэлт төлөвлөлт, шинэ техник технологи хэрэглэх гэх мэт)	- Одоо байгаа болон төлөвлөлтийн талбай орчмын байгалийн жалгаараа байгаа үерийн сувгийн ашиглалтын түвшин тодорхойлж уялдуулан төлөвлөх - Инженерийн бэлтгэл арга хэмжээний шугам сүлжээний ажлын зургийг даалгаварын тогтоосон байршилд гаргалгааг тооцож холболтын цэгийг тогтоох - Инженерийн бэлтгэл арга хэмжээний шугам сүлжээний хамгаалалтын зурвасын дагуу тохижилтын ажил хийх, орчны аюулгүй байдлыг хангах - Инженерийн бэлтгэл арга хэмжээний шугам сүлжээний ашиглалт, техникийн засвар үйлчилгээнд зориулан явган хүний зам, авто машины гүүр, явган хүний гүүр зэргийг орчны тохижилт төлөвлөлттэй уялдуулан норм дүрмийг ханган төлөвлөх. - Инженерийн бэлтгэл арга хэмжээний шугам сүлжээний байгууламжийн усыг хуримтлуулах сантай болгох, дахин ашиглах боломжийн судалгаа, ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлт, усалгаа, зам талбайн угаалга, машин угаалгын газарт ашиглахаар тусгах

ХЯНАСАН:

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАР, ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА — Б.ОЮУНТУЯА

ЗӨВШӨӨРСӨН:

СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА — М.БЯМБАСҮРЭН

БОЛОВСРУУЛСАН:

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАР, ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН УСНЫ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН — Б.ЦОЛМОН

СҮХБААТАР ДҮҮРГИЙН 15,17 ДУГААР ХОРООНЫ ИНЖЕНЕРИЙН БЭЛТГЭЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВРЫН ХАВСРАЛТ

ХӨРӨНГӨ ШИЙДВЭР: НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН 166 ДУГААР ТОГТООЛ ОРОН НУТГИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР

ЗАХИАЛАГЧ: СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

БАЙРШИЛ : СҮХБААТАР ДҮҮРГИЙН 15.17 ДУГААР ХОРОО



СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАРТ

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 166 дугаар тогтоолоор батлагдсан Нийтийн эдэлбэр газрыг дахин төлөвлөн байгуулах журмын 3.1.1 дэх заалтын дагуу хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх тохижилтын ажлын байршлыг холбогдох материалын хамт хүргүүлэв.

Зураг төслийн даалгавар баталж, хамтран ажиллана уу

Хавсралт 14 хуудастай.

Сүхбаатар Дүүргийн Засаг Даргын Тамгын Газар
Төлөвлөлт, Гүйцэтгэлийн Удирдлагын Хэлтэс
Хэлтсийн Дарга
Мөрөндэлгэр Бямбасуран
2023.04.20 11:30

Одоо байгаа Сэлбэ голын үерийн хамгаалалтын суваг

Шинээр хийх үерийн суваг

Шинээр хийх хөрсний болон борооны усны шугам

Төлөвлөлтийн шийдэл:

Шинээр үерийн суваг, борооны болон хөрсний усны шугам хийж одоо байгаа Сэлбэ голын үерийн хамгаалалтын сувагт холбохоор төлөвлөв.

УС ЗАЙЛУУЛАХ ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ЗУРГИЙН ДААЛГАВАР

(Дугаар:СБД ..... Ус зайлуулах шугам сүлжээ хийх зургийн даалгаврын хавсралт)

Байршил	Зориулалт
Сүхбаатар дүүрэг 15 дугаар хороо	Үерийн усны шугамны иж бүрэн зураг төсөл хийх



Таних тэмдэг

Төлөвлөж буй байршил

Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар	Монгол улс, Улаанбаатар хот-14192, Сүхбаатар дүүргийн 7-р хороо, Денверийн гудамж, Иргэдэд үйлчлэх төв байр, Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар Утас:70070123

УС ЗАЙЛУУЛАХ ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ЗУРГИЙН ДААЛГАВАР

(Дугаар:СБД ..... Ус зайлуулах шугам сүлжээ хийх зургийн даалгаврын хавсралт)

Байршил	Зориулалт
Сүхбаатар дүүрэг 17 дугаар хороо	Үерийн усны шугамны иж бүрэн зураг төсөл хийх



Таних тэмдэг

Төлөвлөж буй байршил

Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар	Монгол улс, Улаанбаатар хот-14192, Сүхбаатар дүүргийн 7-р хороо, Денверийн гудамж, Иргэдэд үйлчлэх төв байр, Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар Утас:70070123